МЭДЭЭ · 2026 оны 10-р сарын 13

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН ШХАБ-ЫН ГИШҮҮН ОРНУУДЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРУУДЫН ЧУУЛГАНД ОРОЛЦЛОО




Монгол Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан ОХУ-ын Казань хотноо зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын гишүүн орнуудын ерөнхий прокуроруудын чуулганд ажиглагчийн статустайгаар оролцлоо.



Энэ удаагийн чуулганыг “Гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийг хамгаалах, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах” сэдвийн дор зохион байгуулжээ.

Чуулганд Орос, Азербайжан, Беларус, Казахстан, Катар, Киргиз, Кувейт, Лаос, Мальдив, Тажикистан, Узбекистан, Иран, Пакистан, Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Энэтхэг, Шри Ланка, Хятад, Афганистан, Турк зэрэг 20 гаруй улсын ерөнхий прокурор болон бусад албан тушаалтнууд оролцлоо.



Прокурорын байгууллагууд хооронд харилцан мэдээлэл, туршлага солилцох, тэр дундаа интернет орчинд хүүхдийн эрхийг хамгаалахад улс орон бүр хүчин чармайлт гаргаж, хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар оролцогчид санал солилцов.



Дээрх чуулганы үеэр Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан ОХУ-ын ерөнхий прокурор А.В.Гуцан, Казахстан Улсын ерөнхий прокурор Б.Н.Асылов нартай хоёр талын уулзалт хийлээ.





ШХАБ-ын гишүүн орнуудын ерөнхий прокуроруудын дараагийн чуулган Узбекистан Улсад зохион байгуулагдахаар болсон байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=sMo5NeYT3i8

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/421